



premium



Санхүү, үйл ажиллагааны гүйцэтгэлийн товч танилцуулга – 2024 оны 3-р улирал

Премиум Нэксус ХК


MSE: CUMN

2024 оны 10-р сарын 29

1. CU бизнесийн харьцуулсан болон нийт дэлгүүрийн гүйцэтгэл
2. CU бизнесийн стратегийн зорилтууд
3. Бусад охин компаниуд
4. Премиум Нэксус ХК нэгтгэсэн санхүү, үйл ажиллагааны тайлан
 - а) Орлого, үр дүнгийн голлох үзүүлэлт
 - б) Санхүүгийн байдлын тайлангийн гол үзүүлэлт
 - с) Мөнгөн гүйлгээний тайлангийн гол үзүүлэлт
5. Хувьцааны үнийн хөдөлгөөн

▲ Цэвэр борлуулалт /тэрбум төгрөг/

■ Дэлгүүрийн тоо



Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

	2024 3-р улирал
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	25.6%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	9.5%
Сагсны үнийн өсөлт	14.7%


Харьцуулсан дэлгүүрийн тоо - 311

Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

	2024 3-р улирал
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	22.7%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	5.3%
Сагсны үнийн өсөлт	16.5%

Нийт дэлгүүр дэлгүүрийн тоо: 349 → 415

2024 оны 8-р сараар жилийн инфляц 6.5% байхад харьцуулсан дэлгүүрийн хэрэглэгчдийн сагсны хэмжээ дунджаар 14%-аар өссөн нь худалдан авагчдын сагсны хэмжээ бодит 7%-ын өсөлт үзүүлснийг харуулж байна.



Дэлгүүрийн тэлэлт Q3	
Улаанбаатар	10 шинэ дэлгүүр
Орон нутаг	12 шинэ дэлгүүр
Нийт*	22 шинэ дэлгүүр*

Шинээр тэлсэн аймаг Q3
Өмнөговь
Дундговь
Булган




CU 400 дахь салбар


Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд CU конвиниенс дэлгүүрийн 400 дахь салбар нээгдэв. Ингэснээр орон нутагт хүнсний аюулгүй байдлыг хангасан олон улсын стандартын үйлчилгээгээр хангаж, аялал жуулчлал, үйлчилгээний дэд бүтцийг сайжруулан шинээр ажлын байр бий болгон, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллаж байна.

*3-р улиралд нэг дэлгүүр хаасан.


CU PAY төлбөрийн шийдэл



CU pay
идэвхжүүлэх



QR кодыг посс-ын
машинд уншуулах



Төлбөр төлөгдөж,
Оноо цугларж,
Ибаримт бүртгэгдэх

CU PAY төлбөрийн шийдэл

- ✓ Илүү хурдан төлбөр төлөх
- ✓ Гуравдагч төлбөрийн апп ашиглах шаардлагагүй
- ✓ Гүйлгээний нууц үг хийх шаардлагагүй
- ✓ Ибаримт автоматаар шивэгдэнэ

Төлбөр төлөх дундаж хугацаа

Банкны карт	E-wallets	Бэлэн мөнгө	CU app оноо
25сек	30-45сек	20сек	20-30сек

27.4сек дунджаар

CU Pay 6 секунд

Шинээр нэвтэрсэн онцлох бүтээгдэхүүнүүд




Цаг хугацаа, ажиллагаа хэмнэх зорилго бүхий хоол хялбаршуулах хөлдөөсөн хоолны бэлдэц.



Шимт цуврал категорын 5 цулын бүтээгдэхүүнүүд



шорлосон соустай болон энгийн шарсан тахиа



"BEST TRAINING – СУРГАЛТ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ

- 2023-2024 онд сургалтын баг 22,919 ажилтанд 122,981 хүн цагийн сургалтыг 830 удаагийн давтамжтай хүргэжээ.
- 2023-2024 онд сургалтад суусан ажилтнуудаас 1,293 ажилтан карьер зэрэглэл хөндлөн чиглэлд ахисан бол босоо чиглэлд 387 хүн албан тушаал дэвшсэн.

MONGOLIAN LABOR MARKET SUMMIT
Good Workplace Awards 2024

Stora шинэчлэлт 2.0

Стора Централ ХХК нь кросс бордер и-коммерс үйлчилгээг Монголынхоо зах зээлд технологи болон тээвэр ложистикийн цогц шийдлээр үзүүлдэг болоод 3 жилийн нүүрийг үзээд буй. Үүний хүрээнд Америкийн Амазон, Хятадын Таобао гэсэн дэлхийн тэргүүлэгч 2 том онлайн худалдааны платформуос бараа бүтээгдэхүүн захиалах боломжийг олгодог байсан бол 2024 оны 9 сард дараагийн түвшний том шинэчлэлтээ хийн Stora V2.0 хувилбараа танилцуулж хэрэглэгчдийн гар дээр олон шинэ боломжуудыг бий болголоо.

Уг шинэчлэлтийн хүрээнд Монголын хэрэглэгчид Стора-н пдатформуудаар дамжуулан:

- Бүх төрлийн барааг олох боломжтой Америкийн eBay
- Ахуйн бараа хамгийн ихээр худалдан авдаг Costco
- Шинэ загваруудыг цаг алдалгүй авах боломжоор хангах зорилгоор Apple
- Томоохон гоо сайхны брендүүдийн хамгийн чанартай бүтээгдэхүүнийг авах Sephora
- Дэлхийд гарсан шинэ загварыг хүлээлгүй авах боломжийг бий болгохоор Nike
- Шведийн алдарт IKEA брендийг хамгийн хямдаар авах боломжийг олгож V2.0 дээрээ тус тус холбож технологи, тээвэр, захиалгын зөвлөх үйлчилгээний цогц системийг бий болголоо.



StoreForGood

Худалдааны салбар хамгийн их хог хаягдал ялгаруулдаг тул Стора Централ нь үүний эсрэг эко хэрэглээг дэмжин и-коммерс буюу онлайн худалдааны үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчийн худалдан авалтын шинэ зан төлөвт сургаж байгаагаас гадна. 2024 оны 9 сараас эхлэн байгал орчин, хог хаягдлын эсрэг нийгмийн хариуцлагыг цоо шинэ төсөл хөгжүүлж эхэлсэн нь StoreForGood юм.

Уг төслийн хүрээнд Стора Централ нь систем болон дамжуулан солилцох дэд бүтцийг хөгжүүлэн эхний ээлжинд Стора-н хэрэглэгчид:


1. Хуучин ном
2. Хүүхдийн тоглоом
3. Өмсөхөө больсон хувцас зэргийг дахин эргэлтэнд оруулж хоорондоо солилцох боломжийг бий болгож байгаагаараа онцлог.

Эх дэлхийнхээ төлөө хийж чадах хамгийн энгийн зүйл бол эд зүйлсийнхээ насжилтыг нэмэх явдал тул ирээдүйнхээ төлөө ухаалаг сонголт хийх зан төлвийг бий болгох зорилгоор Стора-н эхлүүлсэн Re-commerce хөдөлгөөнд нэгдээрэй.



Байгууллагын захиалгын автомат шийдэл


Стора нь Байгууллагын харилцагч нартаа зориулсан V2.0 шинэчлэсэн хувилбар дээрээ байгууллагын хангамж, тоног төхөөрөмж, оффисын тавилга, электрон бараа зэрэг бүхий л төрлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн худалдан авалтын аутсорсинг үйлчилгээгээ автоматжуулж дижитал шийдлийг бий болгон дахин загварчилсан шинэчлэлтийг хийлээ. Ингэснээр бүхий л төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг албан байгууллагууд өөрсдийн худалдан авалтаа Стора-д даатган гааль, тээвэр, худалдан авалт судалгааны цогц үйлчилгээг авах боломжтой юм.



Санхүүгийн гол үзүүлэлтүүд


Нийт цэвэр борлуулалт

Сая төгрөгөөр




ХТЭХӨАшиг

Сая төгрөгөөр



Цэвэр ашиг/алдагдал

Сая төгрөгөөр




(Сая төгрөгөөр)	2023Q3-9M	2024Q3-9M	Өөрчлөлт
Нийт цэвэр борлуулалт	278,855.4	433,958.0	155,102.6
Борлуулалтын өртөг	264,342.4	353,190.3	88,847.9
Нийт ашиг (алдагдал)	14,513.0	80,767.7	66,254.7
Нийт ашгийн хувь	5.2%	18.6%	13.4%
Үйл ажиллагааны зардал	9,217.6	17,310.0	8,092.3
ХТЭХӨАшиг	5,295.4	63,457.7	
ХТЭХӨАшгийн хувь	1.9%	14.6%	12.7%
Элэгдэл Хорогдол	19,878.4	24,272.7	4,394.3
Мөнгөн бус зүйлс - Олз/(гарз)	1,486.7	2,165.3	678.6
ХТӨАшиг	(13,096.3)	41,350.3	54,446.6
Санхүүжилтийн зардал	12,766.7	14,417.8	1,651.2
Татварын өмнөх ашиг	(25,863.0)	26,932.5	52,795.5
Татварын зардал	(14.4)	582.2	596.6
Цэвэр ашиг/алдагдал	(25,848.6)	26,350.3	52,198.9
Цэвэр ашгийн хувь	-9.3%	6.1%	15.3%

(Сая төгрөгөөр)	2023Q4	2024Q3	Өөрчлөлт
Эргэлтийн хөрөнгө	40,170.3	70,332.2	30,161.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,980.6	9,227.5	6,246.9
Дансны авлага	653.7	4,126.4	3,472.6
Бараа материал	28,250.0	40,764.9	12,514.8
Бусад эргэлтийн хөрөнгө	8,285.9	16,213.5	7,927.6
Эргэлтийн бус хөрөнгө	153,324.6	192,601.0	39,276.5
Биет болон биет бус хөрөнгө	90,196.4	122,028.8	31,832.3
Ашиглах эрхтэй хөрөнгө	50,532.2	52,483.6	1,951.4
Бусад эргэлтийн бус хөрөнгө	12,595.9	18,088.6	5,492.8
НИЙТ ХӨРӨНГӨ	193,494.9	262,933.2	69,438.4
Богино хугацаат өр төлбөр	116,172.9	78,076.4	(38,096.5)
Дансны өглөг	44,851.5	60,732.8	15,881.3
Богино хугацаат зээл	19,969.9	5,509.2	(14,460.8)
Бусад богино хугацаат өр төлбөр	51,351.4	11,834.5	(39,517.0)
Урт хугацаат өр төлбөр	91,590.7	107,385.7	15,795.0
Урт хугацаат зээл	33,882.0	33,974.1	92.1
Бусад урт хугацаат өр төлбөр	57,708.6	73,411.6	15,702.9
Эздийн өмч	(14,268.7)	77,471.2	91,739.8
Энгийн хувьцаа	81,776.9	111,425.2	29,648.3
Нэмж төлөгдсөн капитал	13,820.5	45,757.9	31,937.4
Эздийн өмчийн бусад хэсэг	318.7	4,122.5	3,803.8
Хуримтлагдсан алдагдал	(110,184.8)	(83,834.5)	26,350.3
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	193,494.9	262,933.2	69,438.4

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Сая төгрөгөөр)	2023Q4	2024Q3	Өөрчлөлт
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			-
Мөнгөн орлогын дүн (+)	310,855.9	496,409.3	185,553.4
Мөнгөн зарлагын дүн (-)	(298,597.1)	(437,692.8)	(139,095.6)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,258.8	58,716.5	46,457.7
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			-
Мөнгөн орлогын дүн (+)	100.9	499.2	398.3
Мөнгөн зарлагын дүн (-)	(18,510.8)	(24,554.5)	(6,043.7)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(18,409.9)	(24,055.3)	(5,645.4)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			-
Мөнгөн орлогын дүн (+)	26,800.0	46,081.1	19,281.1
Мөнгөн зарлагын дүн (-)	(31,340.8)	(73,604.3)	(42,263.5)
Хоорондын тооцоо (+/-)	9,329.8	(799.6)	(10,129.4)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,789.1	(28,322.8)	(33,111.9)
			-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү	13.8	(91.5)	(105.3)
			-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,348.2)	6,246.9	7,595.1
			-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,280.7	2,980.6	(1,300.1)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,932.5	9,227.5	6,295.0



Т БАНК

24



Анхаарал
хандуулсанд
баярлалаа

Холбоо барих бол:
IR manager Ц. Номуундалай
И-мэйл: investor@cumongol.mn
Утас: 95109612